



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/807

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “А” дахь заалт, аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөр, халамжийн хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх үйлсэд олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын халамжийн сангийн олголт хариуцсан мэргэжилтэн Т.Мягмарсүрэн, програм хангамж, мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн Ц.Насанчимэг, “Ховдод үйлдвэрлэв” бүтээгдэхүүн борлуулалтын төвийн ажилтан М.Сүнжидмаа, тус газрын харьяа Баруун бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвийн асрагч Т.Төмөрцоож нарыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Т.Мягмарсүрэн, Ц.Насанчимэг, М.Сүнжидмаа, Т.Төмөрцоож нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга /Л.Билэгдэмбэрэл/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ